



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/17

Эрдэнэт

**Хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "г", 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, 78.2.5, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 157 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 5.6 дахь заалт, 2017 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Албан ажлын шаардлагыг харгалзан орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй 25,000,000 төгрөгийн өртөг бүхий Ниссан патрол маркийн суудлын автомашиныг Гадаадын иргэн, харъяатын газарт шилжүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлэх хөрөнгийг актаар хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газарт, санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэлд зохих журмын дагуу өөрчлөлт оруулахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ